

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/539 дүгээр захирамжаар батлагдсан Орон сууцны бодлогын газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн Газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02/03 дугаар албан шаардлагын дагуу төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, гурван талт гэрээ байгуулах, байгуулагдсан гурван талт гэрээ болон төслийн хэрэгжилт хяналт тавих үйл ажиллагаа хангалтгүй байгаа шалтгаан, нөхцөлийг судлан дүгнэлт гаргах, дүгнэлтэд үндэслэн үйл ажиллагааг сайжруулах санал боловсруулан танилцуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ахлагч:	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
---------	--------------------------------------

Гишүүд:	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
---------	-------------------------------------

Гэрээ хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичиг

Бодлогын бичиг баримт хариуцсан мэргэжилтэн

2. Дээрх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, дүгнэлт санал боловсруулан танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ГАНХҮҮ

Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын
2025 оны ... дугаар сарын ... –ны өдрийн ...
дугаар тушаалын хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН 2025 ОНЫ 02/03 ДУГААР АЛБАН ШААРДЛАГЫН
ХҮРЭЭНД ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ,ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТЭД ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үүрэг даалгавар	Хийж хэрэгжүүлэх ажил	Хугацаа
1	2	3	4
1.	Өргөдөл, гомдолд дурдсан асуудал, бүрийг бүрэн судалж, хуулиар тогтоосон хугацаанд үндэслэл бүхий хариу өгч, эцэслэн шийдвэрлэх.Цаашид тухайн төрлийн зөрчил, дутагдлыг дахин давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Иргэдээс 2024 онд байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлуудыг судлах	2025.01.24- 2025.01.30
		Өргөдөл, гомдлыг хуулийн үндэслэлтэй, шуурхай шийдвэрлэж хариуг бүрэн өгсөн эсэхийг хянах	
		Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	
		Өргөдөл, гомдлыг хугацаанд нь үндэслэл бүхий шийдвэрлэн ажиллах талаар албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах	
		Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны 02/03 дугаар албан шаардлагын хүрээнд иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дотоод хяналт, шалгалт хийсэн ажлын тайланг танилцуулах	2025.02.05

ХЯНАСАН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ж.БОЛОРТУЯА

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.БАЯЛАГ